

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Намжил
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 2 |
| 3. Аудитын тайлан | 2 |
| 3.1 Ерөнхий зүйл | 11 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 12 |
| 3.4 Материаллаг байдал | 12 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 12 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 14 |
| 3.8 Аудитын гол асуудал | 14 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 14 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 15 |
| 4. Аудитын илрүүлэлт | 15 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 15 |

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ХАН ХӨХИЙН НУРУУНЫ УЛСЫН
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР
НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЦЭЛМЭГДАЛАЙ ТАНАА

2022.02.24 № УВА-2022/58/НА-СТА-ТЦЗ
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хан хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ



0200200192

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 39,067,913.56 | 37,131,519.85 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 39,067,913.56 | 37,131,519.85 |
| 35400 | Хангамжийн материал | 39,067,913.56 | 37,131,519.85 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 11,800,200.00 | 8,089,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,387,213.56 | 27,742,219.85 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 500,000.00 | 350,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,380,500.00 | 950,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 425,315,170.80 | 382,657,775.70 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 425,315,170.80 | 382,657,775.70 |
| 39200 | Биет хөрөнгө | 421,840,045.77 | 379,345,150.59 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 302,809,727.00 | 302,809,727.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (13,811,374.44) | (20,454,828.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 157,540,573.78 | 110,862,573.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (66,173,083.09) | (39,326,840.53) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 53,473,640.83 | 31,852,770.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (29,675,614.28) | (18,522,810.40) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,714,851.38 | 25,214,841.38 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,053,397.43) | (13,881,671.30) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,133,000.00 | 1,850,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,118,277.98) | (1,058,611.34) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 3,475,125.03 | 3,312,625.11 |
| 39301 | Программ хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (46,874.97) | (209,374.89) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,072,000.00 | 3,072,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 464,383,084.36 | 419,789,295.55 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 464,383,084.36 | 419,789,295.55 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 464,383,084.36 | 419,789,295.55 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 11,033,000.00 | 11,033,000.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 453,350,084.36 | 408,756,295.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 453,350,084.36 | 453,350,084.36 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (44,593,788.81) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 464,383,084.36 | 419,789,295.55 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|-----------------------|-----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 433,306,273.77 | 340,625,900.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 81,523,073.77 | 3,863,700.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 81,523,073.77 | 3,863,700.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 81,523,073.77 | 3,863,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,300,500.00 | 3,863,700.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 772,225,732.77 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 351,783,200.00 | 336,762,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 336,593,200.00 | 329,140,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 336,593,200.00 | 329,140,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 15,190,000.00 | 7,621,900.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 4,190,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захиргаа | 11,000,000.00 | 6,925,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 696,300.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 390,671,301.88 | 381,518,935.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 390,671,301.88 | 381,518,935.15 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 322,123,348.29 | 330,183,607.57 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 177,777,200.00 | 177,289,019 |
| 210101 | Үндсэн цалин | 135,366,046.00 | 143,769,548.00 |
| 210102 | Нэмэгдэл | 36,623,187.00 | 30,265,141.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,013,667.00 | 3,254,330.00 |
| 210105 | Гэрээтийн цалин | 1,774,300.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,147,266.54 | 22,837,083.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,122,238.74 | 16,174,254.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,805,368.70 | 1,793,890.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,433,690.17 | 1,428,392.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 337,951.45 | 312,776.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,448,017.48 | 3,127,769.66 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,589,109.45 | 7,910,002.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 310,073.00 | 303,382.04 |
| 210302 | Түлш, халаалт | 7,229,036.45 | 7,556,620.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 | 50,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,173,451.00 | 24,365,218.71 |

| | | | |
|-------------|--|----------------------|------------------------|
| 210401 | Бичиг хэрэг | 3,997,500.00 | 4,433,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,999,501.00 | 13,050,360.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,579,550.00 | 1,385,165.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,596,900.00 | 5,496,593.71 |
| 2105 | Нормативт зардал | 5,716,322.05 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,716,322.05 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,644,600.00 | 2,890,100.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | | 1,482,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,644,600.00 | 1,407,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,234,000.00 | 1,401,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,234,000.00 | 1,401,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 39,957,086.20 | 54,533,942.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,267,511.20 | 53,550,317.60 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 120,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 215,775.00 | 333,525.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,000.00 | 78,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 19,800.00 | |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 250,000.00 | 247,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,884,313.05 | 38,956,641.44 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,884,313.05 | 38,956,641.44 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 68,547,953.59 | 51,335,327.58 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 1,196,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 1,196,300.00 |
| | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 68,547,953.59 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 68,547,953.59 | |
| | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт | | 50,139,027.58 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 50,139,027.58 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 42,634,971.89 | (40,893,035.15) |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ҮР ДҮН | | 3,700,753.66 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 3,700,753.66 |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | | (3,700,753.66) |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 42,634,971.89 | (44,593,788.81) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|-----------------------|-----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 356,083,700.00 | 340,625,900.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,300,500.00 | 3,863,700.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,300,500.00 | 3,863,700.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,300,500.00 | 3,863,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,300,500.00 | 3,863,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 351,783,200.00 | 336,762,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 336,593,200.00 | 329,140,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 336,593,200.00 | 329,140,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 15,190,000.00 | 7,621,900.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 4,190,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,000,000.00 | 6,925,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 696,300.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 355,898,700.00 | 340,625,900.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 355,898,700.00 | 340,625,900.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 287,350,746.41 | 289,290,572.42 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 177,777,200.00 | 177,289,019.00 |
| 210101 | Үндсэн цалин | 135,366,046.00 | 143,769,548.00 |
| 210102 | Нэмэгдэл | 36,623,187.00 | 30,265,141.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,013,667.00 | 3,254,330.00 |
| 210104 | Урамшуулал | 1,774,300.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,147,264.54 | 22,837,083.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,122,238.74 | 16,174,254.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,805,368.70 | 1,793,890.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,433,690.17 | 1,428,392.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 337,951.45 | 312,776.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,448,015.48 | 3,127,769.66 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,589,109.45 | 7,910,002.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 211,468.00 | 303,382.04 |
| 210302 | Түлш, халаалт | 6,605,641.45 | 7,556,620.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 772,000.00 | 50,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,847,261.00 | 15,544,325.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 356,700.00 | 722,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,422,801.00 | 13,050,360.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,614,560.00 | 1,385,265.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 453,200.00 | 386,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 217,800.00 | 217,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 217,800.00 | 217,800.00 |

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 286,200.00 | 1,374,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 286,200.00 | 377,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 997,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,234,000.00 | 1,401,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,234,000.00 | 1,401,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 54,251,911.42 | 62,716,742.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 53,562,336.42 | 61,929,617.60 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 127,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 215,775.00 | 333,525.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,000.00 | 78,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 19,800.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 247,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 68,547,953.59 | 51,335,327.58 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 1,196,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 1,196,300.00 |
| | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 68,547,953.59 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 68,547,953.59 | |
| | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 50,139,027.58 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 50,139,027.58 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 185,000.00 | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 185,000.00 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 185,000.00 | |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 185,000.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 185,000.00 | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (185,000.00) | |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 11,033,000.00 | 0 | 396,358,819.50 | 407,391,819.50 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 11,033,000.00 | 0 | 396,358,819.50 | 407,391,819.50 |
| 4 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 0 | 0 | 0 | 0 |
| 5 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 14,356,292.97 | 14,356,292.97 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,103,3000.00 | 0 | 453,350,084.36 | 464,383,084.36 |
| 11 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 11,033,000.00 | 0 | 453,350,084.36 | 464,383,084.36 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 11,033,000.00 | 0 | 453,350,084.36 | 464,383,084.36 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 17 | Гадаад валютын хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -44,593,788.81 | -44,593,788.81 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 11,033,000.00 | 0 | 408,756,295.55 | 419,789,295.55 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|---|----------------------------|----------------------------|---------------------------|-------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 332,140,300.0 0 | 282,864,972.4 2 | 49,275,327.5 8 | 85.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 332,140,300.0 0 | 282,864,972.4 2 | 49,275,327.5 8 | 85.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 332,140,300.0 0 | 282,864,972.4 2 | 49,275,327.5 8 | 85.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 218,115,100.0 0 | 177,289,019.0 0 | 40,826,081 | 81.3 |
| 210101 | Үндсэн цалин | 146,852,600.0 0 | 143,769,548.0 0 | 3,083,052.00 | 97.9 |
| 210102 | Нэмэгдэл | 67,213,600.00 | 30,265,141.00 | 36,948,459.0 0 | 45.0 |
| 210104 | Унаа болон бусад нөхөн олговор | 4,048,900.00 | 3,254,330.00 | 794,570.00 | 80.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,445,500.00 | 22,837,083.78 | 6,608,416.22 | 77.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,720,900.00 | 16,174,254.62 | 4,546,645.38 | 78.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,181,200.00 | 1,793,890.34 | 387,309.66 | 82.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,744,900.00 | 1,428,392.23 | 316,507.77 | 81.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 436,200.00 | 312,776.93 | 123,423.07 | 71.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,362,300.00 | 3,127,769.66 | 1,234,530.34 | 71.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,638,400.00 | 7,910,002.04 | 728,397.96 | 91.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 395,000.00 | 303,382.04 | 91,617.96 | 76.8 |
| 210302 | Түлш, халаалт | 7,557,000.00 | 7,556,620.00 | 380.0.0 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 686,400.00 | 50,000.00 | 636,400.00 | 7.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,546,500.00 | 15,544,325.00 | 2,175.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 722,700.00 | 722,100.00 | 600.00 | 99.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,051,200.00 | 13,050,360.00 | 840.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,386,000.00 | 1,385,265.00 | 735.00 | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 386,600.00 | 386,600.00 | | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 217,800.00 | 217,800.00 | | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 217,800.00 | 217,800.00 | | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,374,000.00 | 1,374,000.00 | | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 377,000.00 | 377,000.00 | | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 997,000.00 | 997,000.00 | | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,308,100.00 | 1,401,600.00 | 906,500.00 | 60.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,308,100.00 | 1,401,600.00 | 906,500.00 | 60.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 56,494,900.00 | 56,291,142.60 | 203,757.40 | 99.6 |

| | | | | | |
|--------|--|-----------------------|-----------------------|---------------------|--------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 55,679,800.00 | 55,504,017.60 | 175,782.40 | 99.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 127,500.00 | 127,500.00 | | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 333,700.00 | 333,525.00 | 175.00 | 99.9 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,100.00 | 78,600.00 | 5,500.00 | 93.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 19,800.00 | | 19,800.00 | |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 250,000.00 | 247,500.00 | 2,500.00 | 99.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 332,140,300.00 | 333,004,000.00 | (863,700.00) | 100.3 |
| | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 329,140,300.00 | 329,140,300.00 | | 100.0 |
| | Улсын төсвөөс санхүүжих | 329,140,300.00 | 329,140,300.00 | | 100.0 |
| | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 3,000,000.00 | 3,863,700.00 | (863,700.00) | 128.8 |
| | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,000,000.00 | 3,863,700.00 | (863,700.00) | 128.8 |
| | БАЙГУУЛЛАГЫН ТОО | | | | |
| | АЖИЛЛАГСДЫН ТОО | 24 | 22 | 2 | 91.7 |
| | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0 |
| | Гүйцэтгэх ажилтан | 16 | 15 | 1 | 93.8 |
| | Үйлчлэх ажилтан | 3 | 3 | | 100.0 |
| | Гэрээт ажилтан | 4 | 3 | 1 | 75.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|------------|--------------|--------------|------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 7,621,900.00 | 7,621,900.00 | |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 7,621,900.00 | 7,621,900.00 | |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 6,425,600.00 | 6,425,600.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | | 6,425,600.00 | 6,425,600.00 | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 6,425,600.00 | 6,425,600.00 | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 1,196,300.00 | 1,196,300.00 | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 1,196,300.00 | 1,196,300.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 1,196,300.00 | 1,196,300.00 | |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 7,621,900.00 | 7,621,900.00 | |
| 31 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 7,621,900.00 | 7,621,900.00 | |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | | 6,425,600.00 | 6,425,600.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 1,196,300.00 | 1,196,300.00 | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хан хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хан хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хан Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь Хамгаалалтын захиргаанд үйлчилдэг хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган биелүүлэх, орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэдийн оролцоотойгоор байгаль орчныг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Увс аймгийн прокурорын газраас Хан Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлыг 2021 оны 9 дүгээр сарын байдлаар шалгасан байна.

Шалгалтаар 6 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 398 дугаар бичгээр Хан Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны газарт хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг Хан Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаар бичгээр хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хан Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 390,671.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,906.7 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 381,518.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,815.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,052.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хан Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,593.8 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|-----------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 39,067.9 | 37,131.5 | -1,936.4 |
| Үндсэн хөрөнгө | 425,315.2 | 382,657.8 | -42,657.4 |

| | | | |
|---|-----------|-----------|-----------|
| Нийт хөрөнгө | 464,383.1 | 419,789.3 | -44,593.8 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 464,383.1 | 419,789.3 | -44,593.8 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 464,383.1 | 419,789.3 | -44,593.8 |

Бараа материалын дансны үлдэгдэл 37,131.5 мянган төгрөг болж 1,936.4 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн материал, сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл буурсантай холбоотой байна.

Бичиг хэргийн материал 4,433.1 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 1,241.0 мянган төгрөг, аж ахуйн материал 8,836.4 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,430.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 382,657.8 мянган төгрөг болж 42,657.4 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалсан.

Үндсэн хөрөнгөөс акталж устгасан 73,081.9 мянган төгрөг байна. Үүнд: Авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгүүд хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 419,789.3 мянган төгрөг болж 44,593.8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө хасагдсанаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 92,680.4 мянган төгрөгөөр буюу 21.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс буурахад үнэ төлбөргүй хүлээн авсан орлого голчлон нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 9,152.4 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамжийн бараа материал, албан томилолтын зардлууд байна. Энэ нь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан болон Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 337,320.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 337,320.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,061.9 мянган төгрөгөөр бууруулж 335,258.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 335,258.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 332,258.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 3,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 329,140.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 3,863.7 мянган төгрөг, нийт 333,004.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 282,865.0 мянган төгрөгийг зарцуулж 50,139.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 282,865.0 мянган төгрөг буюу 85 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 7,621.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 7,621.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Хан Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 144, хугацаа хоцроож мэдээлсэн 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,859.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад залруулга хийлгэв. Үүнд:

4.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчин тооцоо үүсгэхгүйгээр шууд зардалд бүртгэсэн 5,859.0 мянган төгрөгийн гүйлгээ байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|---|----------------------|---------|-----------|---------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хан хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа | 1 | 5,859.0 | 1 | 5,859.0 | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 21-ний өдөр